



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/172

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх эрх олгох дуудлага
худалдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10, 2020 оны 152 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 15 дугаар тушаал, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2021 оны VIII хуралдааны 03, 2022 оны ээлжит IX хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрх олгох дуудлага худалдааг явуулах 2 нэгж талбарын газрын хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, дэнчингийн хэмжээ, дуудлага худалдаа явуулах товын хугацааг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг явуулах бэлтгэл ажлыг хангаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу цахимаар зохион байгуулж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр)- нарт тус тус үүрэг болгосугай.


ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24 өдрийн
А/137. Дугаар захирамжийн хавсралт

Хөвсгөл аймагт газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны газрын
байршил, эзэмших хугацаа, хэмжээ, зориулалт, анхны үнэ, дэнчингийн хэмжээ, явуулах хугацаа



№	Эзэмшүүлэх газрын байршил	Газар эзэмшүүлэх зориулалт	Газар эзэмшүүлэх хугацаа	Эзэмшүүлэх газрын хэмжээ /м2/	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ / мян.төг/	Дэнчингийн үнэ /төг/	төлөвлөлтийн нэгж талбар	Дуудлага худалдаа явуулах хугацаа
1	13-р баг Дулааны станцын ар талд	Үйлдвэрлэлийн барилга байгууламж бусад газар	15	1309	5890500	589050	2638307	2022.06.27 өдрийн 9 цаг 00 мин- 15 цаг 00 мин
2	13-р баг Радио өргөн нэвтрүүлэх станцон зүүн урд талд	нэхмэл эдлэл, хувцас арьсан эдлэлийн үйлдвэр	15	10080	45360000	4536000	2696172	2022.06.27 өдрийн 9 цаг 00 мин- 15 цаг 00 мин
	Дүн			11389	51250500	5125050		

___оОо___